

Манмин Мэдээ

№ 62 2018 оны 7 сарын 22

Бурханы хайр ба эрх мэдэлт хүчээр дүүрэн Манмин



“Бурханы эрх мэдэлт хүчээр авралын зар түгээдэг чуулган юм”

Өнөө үед олон чуулганд авралын зар түгээх нь асуудал болж буй үед Манмин төв чуулган нь бүтээгч Бурханы эрх мэдэлт хүчээр эр зоригтойгоор Есүс Христийн нэрийг дэлхий даяар тунхагладаг маш онцгой чуулган юм. Бүх дэлхий даяар авралын зар тараах үйлсийг бүх сэтгэлээрээ дэмжин буй И Жей руг докторын алсын хараа ба сүнслэг удирдамжийн тусламжтайгаар Эзэний авралын зарыг Манмин төв чуулган эрч хүчтэйгээр тунхаглаж байна. Түүнчлэн И Жей руг докторын удирддаг GCN (Жи Си Эн) телевиз нь NRB (Дэлхий даяарх Христийн телевизийн холбоо)-ны гишүүний хувьд бусдаас илт давуу, дээд зэргийн дуу дүрсний өндөр чадвартай, Христийн өргөн нэвтрүүлэг, төрөл бүрийн хөтөлбөрүүдээр Христийн телевизүүдийн өнөөгийн нүүр царай болсоор байгаа юм.

- Доктор Френк Райт
NRB(Дэлхий даяарх Христийн телевизийн холбоо)-ны ерөнхий захирал, АНУ



“Эболо вирусиг устгасан Эзэний хүчийг магтъя”

Би ямар нэг улс төрийн дэмжлэг байхгүй ч И Жей руг пасторын залбирлаар дамжуулан албан тушаал дэвших ерөөл хүртсэн юм. Хүмүүсийн гүтгэлэг болон буруу ойлголтоор хүнд байдалд байхдаа ч И Жей руг пасторт захидал илгээхэд мөн л залбирал хийж өгсөн юм. Ялангуяа Экуадорийн бүрэн эрхт өргөмжит консул болох үед манай консулийн газарт Эболла вирусын халдвар авсан өвчтөн илэрсэн аюултай нөхцөл байдалд И Жей руг пасторт залбирлын хүсэлт явуулж, залбирал авсан тэр өдрөөс эхлэн нэмж халдварласан тохиолдол нэг ч гараагүй юм. Ингэж Эболла вирусын тархалтыг устгаж өгсөн Бурханы эрх мэдэлт хүчийг магтъя.

- Себьяастин Импаэто Пенго парламентийн гишүүн
Конго бүгд найрамдах улсын Христийн намын дарга



“Библид бүрэн тулгуурладаг, шилдэг чуулган”

Би Манмин төв чуулганаас Европ дах чуулгануудаас мэдэрч үзээгүй Ариун Сүнсний бялхал, халуун байдлыг мэдэрч үзсэн юм. Итгэгч нар бие биенээ хайрлан хүндэлж, харьцдаг бүх зүрх, бүх сэтгэлээр мөргөлдөө оролцож, байгаа тэдний дүр төрх. Үнэхээр Библид бүрэн тулгуурладаг, шилдэг чуулган санагдсан. Энэ бол И Жей руг пасторын зөв зааж сургасных гэж би бодож байна. Бурханы хүч нөлөөг авсан, мэдэрсэн төрөл бүрийн гэрчлэлүүд И Жей руг пасторын залбирлаар бий болох агуу гайхамшигтай тэмдгүүд зэргийг үзээд сэтгэл минь маш их хөдөлсөн юм. WCDN (Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбоо)-ны үйлчлэлээр дамжуулан миний итгэлийн амьдралд сэргэлт ирж, итгэгч хүнийхээ хувьд Бурханы хүч нөлөөг улам их дамжуулахыг хүсч байна.

- Любка Танчева доктор
Болгар, Анагаах ухааны академи,
Мэдрэлийн физиологч



“Израйлийн парламентаас талархал дамжуулж байна”

Израйлийн нэгдсэн их цуглааны үед номлогч И Жей руг пастораар дамжуулан гарсан эрх мэдэлт хүч агуу байсан юм. Ялангуяа тухай үед Израйлд хэдэн жилийн турш гантай, маш хүнд байхад Бурхан И Жей руг пасторын залбиралд хариулан маш их хэмжээний бороог Иерусалим болон бүх Израйль даяар оруулсан юм. И Жей руг пастортой анх уулзахад би Израйлийн иргэдийн төлөөлөгч байсан бол одоо би Израйлийн парламентийн гишүүн ба парламентийн дэд дарга болох ерөөл хүртсэн юм. Залбирал хийж өгсөн И Жей руг пастортаа баярлалаа. Үргэлж Израйлийг хайрлаж, залбирч өгсөнөөр олон ард түмэн эрүүл энх, ажил нь амжилттай байна. Израйлийн парламентаас талархал дамжуулж байна.

- Ехиел Хилик Бар
Израйлийн парламентийн дэд дарга



“Бурхан болон Эзэнтэй уулзах замыг маш тодорхой зааж өгдөг”

Би олон газар явж, И Жей руг доктор болон ариун сайн мэдээг дамжуулж байгаа билээ. Хэдийн олон газарт үй олон хүмүүс И Жей руг пасторын сургаалийг сонсч байгаа бөгөөд Манмин төв чуулганыг ч сайн мэддэг болсон. Энэ нь И Жей руг пастор Бурхан болон Эзэнтэй уулзах замыг маш тодорхой зааж өгдөг учраас юм. Ялангуяа 2017 оны 9-р сард асар хүчтэй “Ома” гэх далай хар шуурга ирэхэд миний байгаа газар болон Флорида мужийн олон оршин суугчид дүрвэж явсан юм. Тэр үед И Жей руг пасторын залбирлын хүсэлт явуулаад ямар айх зүйлгүй тэнд үлдсэн юм. И Жей руг пасторын залбирлаар Бурхан тэр далайн хар шуурганы чиглэлийг өөрчлөн хүч нь замхаруулсан ба бид ямарч аюулгүй сахин хамгаалагдсан юм.

- Михайл Муглис доктор
Сүнслэг дипломат төвийн захирал, АНУ



“Эцсийн үед бүх дэлхий рүү хандсан Бурханы төлөвлөгөө”

Миний мэдэх манмин нь үнэхээр гайхалтай чуулган юм. И Жей руг пастор Бурханы хаанчлалыг агуу ихээр тэлэхийн тулд агуу хүч нөлөө дагуулдаг номлогч хэдий ч маш даруу дөлгөөн бөгөөд түүний энэ эгэл бөгөөд халуун дотно дүр төрх үнэхээр гүн сэтгэгдэл төрүүлдэг. Мөн Эзэний эрх мэдэлт хүч, тэмдэг гайхамшиг хамт байх И Жей руг пасторын үйлчлэлийг дэлхийн хаанаас ч олж үзмээргүй гэмээр. Манмин бол бүх тал дээр сүнслэг бөгөөд эрч хүчтэй юм. Түүнчлэн энэ цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тэмдэг гайхамшиг, эрх мэдэлт хүчийг үзүүлж байгаа юм. Энэ бол хүн төрөлхтөний эцсийн үед бүх дэлхий рүү хандсан Бурханы агуу гайхалтай, сүр жавхлантай төлөвлөгөө гэдэгт би итгэж байна.

- Франциско Лорите Ехпосито пастор
Мараната сэргэлт чуулган, Испани

Дахин бүтээлийн эрх мэдэлт хүч

“Тэгээд Бурхан-Гэрэл бий болог!
гэсэнд гэрэл бий болов”
(Эхлэл 1:3).



Манмин төв чуулганы тэргүүн пастор,
И Жей руг пастор

- Есүс Христийн нэгдсэн ариун урсгалын ерөнхий удирдагч
- Христийн сайн мэдээ сэргэлтийн холбооны ерөнхийлөгч
- Үндэсний хайрын залбирлын нэгдсэн хорооны хамтын удирдагч
- (GCN) (Жи Си Эн) Глобал Христийн телевизийн ерөнхий захирал
- (WCDN) Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбооны ерөнхий захирал
- (MIS) Манмин олон улсын библийн их сургуулийн захирал
- Нэгдсэн ариун библийн сургуулийн захирал
- Библи судлалын доктор, Теологийн хүндэт доктор
- Христийн телевиз, радиогийн албан ёсны сургаал заагч
- Чусон илбу, Жүнан илбу, Туна илбу, Хангүг илбу, Сөүл сонин Хангёорэ сонин, Кёонхян сонин, Хангүг кёнжэ сонин, Ши са ньюс, Кристиан сонин зэрэг өдөр тутмын сонин, сэтгүүлд итгэлийн амьдралын тухай байнгын нийтлэгч
- АНУ-н Нью-Йорк, Вашингтон, Балтимор, Мерилэнд, Лос-Анжелос, Хавай, Япон, Пакистан, Филиппин, Аргентин, Гондурас, Перу, ОХУ, Герман, Кени, Танзани, Уганда, Конго бүгд найрамдах улс, Израйль Иерусалим, Эстони зэрэг улс орнуудад нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан

Бүтээгч Бурхан тэнгэр газар, түмэн бодисыг бүтээхийн өмнө “Гэрэл бий бол” гэж айлдахад гэрэл бий болсон шиг дахин бүтээлийн эрх мэдэлт хүч нь угийн дуугаар биелэгдэх хүч нөлөө юм.

Бурханы товлосон бүтээлийн дэг журмийн дагуу угийн дуу хоолойг чөлөөтэй, зөв зохистойгоор сэтгэлдээ өвөрлөн уг дуу хоолойг гарсанаар бий болох боломжтой. Тэгвэл одоо энэ дахин бүтээлийн хүчийн тухай авч үзэцгээе.

1. Дахин бүтээлийн хүч гэж юу вэ?

Үүнийг жишээ дурьдвал “цэцэг” огт байхгүй газар цэцэг бий болгох бус үхсэн хатсан цэцгийг эргэж сэргээх хүч нөлөө гэж ойлгож болох юм. Цэцгийг бий болгох бүтээлийн хүч нь зөвхөн бүтээгч Бурханд орших бөгөөд зөвхөн Тэр л бий болгож чадах юм. Энэ мэт Бурханы үзэсгэлэнтэйгээр бүтээсэн зүйл эвдэгдэх, сүйтгэгдэх үед дахин сэргээх үхмэл болсоныг нь амьдруулж, газар тэнгэрийн хооронд буй бүх зүйлийг шинэчилж чадах хүч нөлөөг дахин бүтээлийн хүч гэдэг.

Тэгвэл гэмт үйлдлүүд дэндүү их болсон өнөө үед “Дахин бүтээлийн хүч”-ээр дахин шинэчлэхийн тулд 1-рт юу хийх ёстой вэ? “Хүн”-г шинэчлэх юм. Хүн бол Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн ба (Эхлэл 1:27) анхны хүн Адамын гэм нүглийн улмаас Бурханы дүр төрхийг алдсан юм. Бурхан Есүс Христээр дамжуулан авралын замыг нээж өгсөн ч эцсийн үе ойртох тусам хүмүүс аврал хүртэх итгэлээ ч хадгалахад амар биш болсон юм. Ертөнцийн ёс бус, хууль бус зүйлд ихээр автаж, тэр ч байтугай Христчин хүмүүст ч энэ мэт зүйл газар авсаар байна.

Ийм эцсийн үед амьдарч буй хүмүүсийн төлөө Бурхан цөхрөлтгүй зүтгэж, тэдний шархалсан сэтгэлийг эдгээж, бохирлогдсон сэтгэлийг цэвэрлэж өгөхийг хүсдэг. Алдагдсан Бурханы төрхийг сэргээж чадах дахин бүтээлийн хүчээр нөлөөлж өгөхийг хүсдэг. “Тэр хүн огт аврал авч чадахгүй” гэх хүнд ч дахин авралын боломжыг өгөхийг хүсдэг нь “Бурханы угийн хайр” юм.

Дахин бүтээлийн хүч нь Бурханы ийм угийн хайраас эхлэлтэй юм. Тиймээс ч дахин бүтээлийн хүчийг авах хүртэл Бурханы угийн хайрыг дагасан тийм хайрыг илэрхийлэн гаргах ёстой байдаг. Шударга ёсны хуулиар үзэхэд аврал хүртэхэд хэцүү хүнийг аврахын тулд түүнд тохирсон төлөөсийг төлөх ёстой.

“Гэмийн хөлс бол үхэл” (Ром 6:23) гэсэн хуулиар бол үхлээс амь руу оруулахын тулд хэн нэгэн өмнөөс нь төлөөсийг нь төлөх золиослол хэрэгтэй гэсэн үг юм. Есүс модон загалмайд өлгөгдсөн нь “Гэмийн хөлс бол үхэл” гэсэн хараалыг өмнөөс нь авахын төлөө байсан бөгөөд гэмтнүүдийн гэмийг цайруулахын тулд ямар гэм зэм, өө сэвгүй Есүс үнэт цусаа урсгах ёстой байсан юм. Тэгээд үхлийн хүчийг ялан дийлж, дахин амилсан “Есүс Христэд итгэсэн хэн ч гэм нүглээсээ уучлагдаж, Бурхан хүүхэд болно” гэсэн шинэ хууль, зарчим бий болсон юм.

Үүний нэгэн адилаар аврал хүртэхийн аргагүй хүмүүсийг аврал руу хөтлөхийн төлөө шударга ёсны хуулийг бий болгохын тулд түүнд нийцэх золиос байх шаардлагатай юм. Хатуу чанд хуулийн дагуу аврал хүртэх боломжгүй хүмүүс ч авралын боломжыг авах зам болдог. Энэ мэт өргөтгөсөн цар хүрээ бүхий

шударга ёсны хуулиар Солонгосын орон нутагт болон дэлхий даяар үй олон хүмүүсийг агуулах боломжтой юм. Тэр ч байтугай дэндүү атгаг, хүн чанараа алдсан хүмүүс ч зүрх сэтгэлийг нь өөрчилж, Бурханы өмнө өвдөг сөгдөх хэмжээнд хүртэл үйлчилдэг гэсэн үг юм.

Үүнийг бий болгох гол хүч нь дахин бүтээлийн хүч юм. Айдас дотор хүчээр итгэх биш хайрыг мэдэрч, зүрх сэтгэл нь зөөлөрч, өөрийн чөлөөт сонголтоор Бурханд итгэх болдог.

2. Хатуу сэтгэлийг хаяж, зүрх сэтгэлийг өөрчлөгч дахин бүтээлийн хүч

Езекиел 36:26-27д “Түүнээс гадна, Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг оруулна. Би та нарын махан биеэс чулуун зүрхийг зайлуулж, та нарт махан зүрхийг өгнө. Би Өөрийн Сүнсийг та нарын дотор оруулж, та нарыг Өөрийн тогтоолуудаар явуулна. Та нар Миний зарлигийг сахихад анхаарах болно” гэсэн байдаг.

Энэ нь Израйлийг сэргэх үед өгсөн эш үзүүлэг бөгөөд мөн эцсийн үед бий болох дахин бүтээлийн хүчийн тухай эш үзүүлэг юм. Хорон муугаар хатуурсан сэтгэлийг ч дахин бүтээлийн хүчээр зөөллөж болох тухай юм. Ингэж зөөлөн сэтгэлтэй болвол Бурханы үгийн дагуу амьдрах боломжтой болдог.

Мөн Езекиел номын 37-р бүлэгт Езекиел үзэгдэл дунд хувхайрсан араг яснууд эргэн амилж их цэрэг болдог үйл явдал гардаг. Езекиелийг харж байхад тэр хөндийд асар их араг яс хувхайрсан байдалтай байв. Тэр үед Бурхан Езекиелээр дамжуулан тэр яснуудад хандан үгээ айлдсан юм. Тэгтэл яснууд хөдөлж, хоорондоо эвлэрч буй дуу гарч байв. Түүний дараа булчин шөрмөс бий болж мах болон арьсаар хучигдав.

Энэ удаад Бурхан мөн л Езекиелээр л дамжуулан тэдгээрт амийн амьсгалийг үлээлгэхэд дөрвөн зүгээс амийн амьсгал хүчтэй салхилан, тэдгээрт орж, амилуулж тэд хөл босон жагсаж, агуу их цэрэг болсон юм. Энэ бол дахин бүтээлийн хүч юм.

Энд өгүүлж буй “Хувхайрсан яс” гэдэг нь огт амилах, амьдрах боломжгүй зүйлийг илэрхийлж байгаа юм. Өнөө үед хувхайрсан яс мэт огт амилах боломжгүй хүмүүс, сүнс сэтгэл нь атгаг, хувирамтгай, хэрэгцээгүй болсон хүмүүс маш их байгаа юм. Ийм хүмүүс дахин бүтээлийн хүчээр дахин сэргэж, цэвэрлэгдэн, өөрчлөгдөх боломжтой юм.

Хайрын Бурхан гэм нүглээр дүүрсэн цаг үед амьдарч буй хүмүүс дахин бүтээлийн хүчийг хараад ч гэсэн Бурханы амьд оршин байгааг болон библийн үнэн болохыг итгэж, аврал авч, тэдэнд бэлдсэн сайхан тэнгэрийн орон руу орж ирэхийг хүсдэг учраас энэ мэт эцсийн үед төлөвлөсөн юм.

3. Тэрслүү үеийнхэнийг шинэчилж өгдөг дахин бүтээлийн хүч

1) Корагийн бүлэг шиг Бурханы хүнийг эсэргүүцдэг хүмүүс.

Тооллого номын 16-р бүлэгт үзвэл Кора болон Датан зэрэг хүмүүс бүлэглэн Мосе эш үзүүлэгчийн эсрэг тэрээлдэг үйл явдал гардаг. Кора бол Леви хүн бөгөөд Бурхан өргөөнд үйлчилдэг үүргээ чамлаж, тэргүүн тахилч болохыг хүсдэг байв. Мөн Датан болон Абирам нарын бүлэг ч Мосе Египтээс өөрсдийг нь


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо
Орхоны 1-33А Чуулганы
ахлагч П.Батзориг

Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

гаргаад цөл аваачин үргэлж зовоож байгаа тухай хэлж эсэргүүцдэг.

Энэ нь Бурханыг харахад дэндүү атгаг үйлдэл байсан бөгөөд эцэст нь газар хуваагдаж, тэднийг болон гэр бүлийнхэнийг, Корад хамаарах бүх хүмүүсийг амьдаар нь эд хогшилтой нь хамт залгиж үхэгсдийн оронд унагааж, газар эргээд хаагдсан юм (Тооллого 16:32-33). Үүнээс харахад тэдний атгаг үйлдэл хичнээн том байсныг мэдэж болох юм.

Хуучин гэрээний үед энэ мэт Бурхантай тэрсэлдэхтэй адил том гэм нүгэл нь шинэ гэрээний үед Ариун Сүнснийг доромжлох, эсэргүүцэх, саад хийх явдал юм. Марк номын 3:29д Есүс “Харин Ариун Сүнснийг доромжлогч хэн ч хэзээ ч уучлагдахгүй бөгөөд мөнх нүглийн гэмтэн болно гэв” гэж айлдсан байдаг.

Гэтэл өнөө үед Бурханд итгэдэг гэдэг ч Ариун Сүнснийг доромжлох, эсэргүүцэх, саад хийдэг хүмүүс цөөнгүй байдаг. Үнэхээр маш тодорхой Бурхан хамт байгаа баталгаа үзүүлсэн ч өөрсдийн атгаг байдлаас болж үүнд итгэдэггүй. Харин ч эсрэгээрээ Бурханы хүнийг дүгнэж, шүүн, гоочлон муулдаг. Энэ нь Бурханыг тэгж байгаатай адил учир уучлагдах аргагүй юм.

Гэсэн ч Бурхан ийм хүмүүсүүдийг ч гэмшин эргэж, авралын боломжыг бариулахын тулд дахин бүтээлийн хүчийг бий болгосон юм.

2) Искариотын Иудас, Ананиа, Сапфир мэт Ариун Сүнснийг хуурч, Эзэнээс урвасан хүмүүс.

Искариотын Иудас өөрийн аар саар ашгийн төлөө Есүсийг дагаж байлаа. Есүс махан талаар хүчтэй байр суурь эзлэвэл өөрөө ч Түүний хажууд байх болно гэж горьдож байлаа. Мөнгөний уутыг хариуцдаг байсан тэрээр заримдаа мөнгийг дураараа хэрэглэдэг байлаа.

Тэгтэл Есүс өөрийнх бодож, найдаж байснаас өөр тийш явж буй мэдсэн тэрээр Есүсийг гучин мөнгөн зоосоор зарж орхидог. Эцэст нь тэрээр түрүүлгээ харан гэдсээ хүүлэн, гэдэс цувуулан аймшигтайгаар төгссөн юм (Үйлс 1:18). Өөрийн

шуналаас болж Эзэнээс урвасаны үр дүн нь маш эмгэнэлтэй харамсаар төгссөн юм.

Үйлс номын 5-р бүлэгт гардаг Ананиа, Сапфир гэх гэр бүлийн хоёр анхны цуглаан гал мэт Ариун Сүнсний хүч нөлөөгөөр ивээл авч, өөрсдийн газраа зараад өргөө гэж амлсан байдаг. Гэтэл яг мөнгөтэй болоод ирэх үед тэдний шунал хөдөлж, газрынхаа мөнгөний тодорхой хэсгийг авч нуун, хэсэгхэнийг л цуглаанд өргөсөн юм. Тэгтэл эрх мэдэлт хүчтэй элч Петр Ариун Сүнсний тод онгод дотор Ананиа, Сапфирыг зэмлэж, тэд гэмшилгүй харин эсрэгээр худал хэлснээр тэр дороо байсан газраа үхдэг.

Энэ мэтчилэн ивээл авсан ч Ариун Сүнснийг хуурах явдал асар том гэм юм. Ариун Сүнсний хүчийг үйлддэг элч Петрийг Ананиа, Сапфир хуурсан нь эцэстээ Ариун Сүнснийг хуурсантай адил юм.

Мөн түмэн цэргийн Эзэн Бурханы өмнө амлалтаа сахиж чадахгүй бол тэр нь Бурханы хуурсантай адил тул эцэстээ авралын асуудал бий болдог. Тиймд Бурханы өмнө хамаагүй амлалт өгөх зүйл биш бөгөөд үнэхээр амлалтаа сахиж чадах итгэлтэй мөн сахин биелүүлвэл агуу том ерөөл юм.

Гэтэл эцсийн үед итгэгч хүмүүсээс ч илүү хорон мууг үйлддэг хүмүүс олширч байгаа нь харамсалтай юм. Бурхан ийм хүмүүсийг ч гэсэн аврахыг хүсэж байгаа тул дахин бүтээлийн хүчээр тэдэнд хайрыг мэдрүүлж, тэднийг гэмшүүлж, авралд хүргэх боломжыг барихыг хүсдэг.

3) Фарисайчууд, хуулийн багш нар шиг хатуу баримтлалаар Ариун Сүнсний хүч нөлөөг эсэргүүцдэг хүмүүс.

Есүсийн үйлчилж байх тухайн үед фарисайчууд, хуулийн багш нар хуучин гэрээний хуулийг ишлэлээр цээжлэх хэмжээний сайн мэддэг байлаа. Гэхдээ Бурхан библийг өгсөн жинхэнэ утгыг ойлголтгүй мэдлэг төдий сурч байв.

Иохан номын 5:39д Есүс “...Тэдгээр нь Намайг гэрчилдэг” гэж айлдсан байдаг. Фарисайчууд,

хуулийн багш нар Ариун Сүнсний бялхал дотор библийг уншиж, судалсан бол хуучин гэрээнд маш олон удаа зөгнөсөн Мессиа нь Есүс болохыг таних байсан юм.

Гэвч тэдний дийлэнх нь өөрсдийн ийм мэдлэгтээ сэтгэл нь хатуурсан байдлаар библийг судлах тул үг нь махан бие болж энэ газарт ирсэн Есүс тэдний нүдний өмнө ирсэн ч танилгүй харин ч Есүсийг загалмайд цовдлуулахад гол нөлөө үзүүлдэг.

Өнөө үед сүм чуулгануудад “Би удаан хугацаанд библи ингэж судалсан”, “Би төдөн жил номлолын ажил хийж, Бурханы өмнө өргөсөн цаг хугацаа ийм тийм хэмжээтэй”, “Би Теологи библи судлалын доктор, хэнээс илүү библийг сайн мэднэ” гэдэг хүмүүс байдаг ч Ариун Сүнсний нөлөө сайн авч чаддаггүй тохиолдол их байдаг. Харин ч бардам болж хамаагүй дүгнэж, шүүх гэм хийдэг. Бурханы дахин бүтээлийн хүч чадлаар ийм хүмүүсийн хатуу үзэл баримтлалыг хагалан, тэд нар ч Ариун Сүнсний нөлөөг авч авралын боломжыг авахыг хүсдэг.

Библи бол Ариун Сүнсний бялхалаар л тайлах ёстой ба тэгэхийн тулд маш их мацаг барилт болон залбирлаар сүнсний давхаргыг нэвтэрсэн зүтгэл байх ёстой. Бурхантай холбогдож, Бурханы сэтгэлийг мэдэрч, Түүнийг хүслийг олж мэднэ гэдэг нь маш чухал юм. Гэтэл “Библийг мэднэ” гэсэн хүмүүс ихэнх нь ингэж сүнсний давхаргыг нэвтрэх зүтгэл гаргадаггүй. Тиймээс тэдний хийж чадаагүй хэмжээ хүртэл өмнөөс нь хийж өгснөөр ийм хатуурсан үзэл баримтлалыг хагалж, Ариун Сүнсний нөлөөг авах болдог.

Хайрт итгэгч та бүхэн, Цаг нь болоход үнэндээ бид бүхэн дахин бүтээлийн хүчээр “Манмин” гэх эрч хүчтэй нэрээр бүх дэлхийн хүн төрөлхтөнг аврал руу хөтлөх үүргийг хангалттай биелүүлэх юм. Хүмүүсийг аврал руу өөрчлөнө гэдэг нь эцэстээ хайр болохоор итгэгч та бүхэн маш хурдан хайрын элч болон гарч, эцсийн үеийн зорилгын дагуу хамтдаа биелэгдэхийг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Гайхалтай яа? Үргүйдэлтэй байсан ч хүүхэдтэй болох ерөөл авлаа



И Жей руг тэргүүн пасторын залбирлаар савны суваг бөглөрч, жирэмслэх боломжгүй байсан эхнэр минь эдгэрч, охинтой болсон. Энэтхэг Дели хотын Промод Кумар итгэгч, Биеийн ерөнхий байдал сул доройн улмаас жирэмслэх чадахгүй байсан ч И Жей руг тэргүүн пасторын залбирлаар үр хүүхдийн ерөөл авч 2 хүү, 1 охинтой болсон Чүэ Юүн ёон халамжлагч, Япон, Ямагата, Гэр бүл болоод 12 жилийн дараа хүүхэдтэй болж хадам эцэг эхээ хүртэл цуглаан руу номлосон Жан Геонхэ сүмд үйлчлэгч, Гэр бүл болж 4жилийн дараа эрүүл саруул хүүхэд төрүүлсэн Павари Инконг сүмд үйлчлэгч Тайланд Чиан ма (Зураг 1-4).

Хэвлий дэх охин хүүхэд хүү болж, хүү нь охин болж солигдов



Юүкэриа Ижондү итгэгч АНУ, Нью Жерси муж-н дүүгийнх эхнэр жирэмсэний 9 сартай охин байсан ч тэд хүүтэй болохыг хүссэнээр И Жей руг пасторын залбирлыг авахад тэдний хүссэний дагуу хүү төрүүлсэн. Ким Өн сүг халамжлагч хэвлий дэх хүүхэд охин болохыг мэдээд залбирал авсан дараа хүүтэй болсон. Чэ Ми ёон сүмд үйлчлэгч болон Софи Атейн итгэгч Кени Найроби нар тус тус жирэмсэний 5 сартай хүү байсан ч охинтой болохыг чин сэтгэлээсээ хүссэн тул залбирал авсан дараа охин төрүүлсэн (Зураг 1-4).

Эрх мэдэлт хүчтэй залбирлаар Дауны хам шинж буюу ургын гаж хөгжлийн уршгаас эдгэрч хэвийн төрсөн хүүхдүүд



Эрүүл хүний хромсом 23 хос байдаг ба ураг дах гаж хөгжил нь 21-рх хромсомын гурвал буюу 21-рх хромсомын илүүдэл нэг хромсом агуулах эмгэг буюу Дауны эмгэг гэдэг үүнийг засах хэрэгтэй байдаг. И Мин геон сүмд үйлчлэгч нь жирэмсэний 11 долоо хоногт хэт аваины шинжилгээ хийлгэхэд 4,12мм ургын гаж хөгжил болон удамшлийн өвчний шинж тэмдэг илэрч И Жей руг пасторын

залбирлыг авсаны дараа 2мм болж багассан. Им Сү хи номлогч, Юүн Сон Жин сүмд үйлчлэгч жирэмсэний 4-5 сард шинжилгээ хийлгэхэд. Ким Хэ сүг халамжлагч 16 дах долоо хоногт гаж согогын шинжилгээнд ороход ургын гаж хөгжлийн хэмжээ өндөр байсан ч И Жей руг пасторын залбирлыг авсаны дараа хэвийн болсон (Зураг 1-4).

“Би 23-н жилийн турш сүмдээ яваагүй ч намайг мартаагүй Эзэний хайр”



Ёон Дог хи итгэгч (50 нас, 2-р их бүлэг 14-р хэсэг)

1996 онд би эхнэрээ дагаад Манмин төв сүмд ирж бүртгүүлэн итгэлийн амьдралаа эхлэсэн ч ажилтай, завгүй гэсэн шалтгаанаар сайн явж чадаагүй юм. Миний эхнэр (И Сон Ёон сүмд үйлчлэгч) сүмд ирэх болсон нь эмнэлэгт бүрэн эдгэрэх боломжгүй гэгдэх том хүүгийн Кю Жиний архаг багтраа өвчнийг эдгээгэхийн тулд байсан юм. Амьсгалах тутам аахилан, гүйж чадахгүй ч гүйсэн мэт амьсгал нь давхцсан байдалтай байдаг байв.

Бурханы ивээлээр Кю Жин бага сургуулийн 4-р ангидаа И Жей руг тэргүүн пасторын залбирлаар төгс эдгэрч, одоо их сургуульдаа таеквондоогоор хичээллэдэг том эрүүл

чийрэг залуу болсон юм. Би хөдөө ажилладаг тул долоо хоногийн сүүлээр л гэртээ ирдэг байв. Тэгээд ч тэр юм уу гэртээ л ирвэл амармаар санагдаж, эхнэр минь сэтгэлийг ойлгож өгөн, үйлчилж өгдөг ч аар саар асуудлаас болж хааяа маргалддаг байлаа. Энэ хугацаанд намайг бага багаар үл тоож, итгэлийн амьдрал, сүм гэх эхнэртээ гомдож байсан ч эхнэр өмнөхөөсөө өөрчлөгдөж байгаад харин ч би өөрөөсөө ичдэг байв.

2016 оны 8-р сард Манмин зуны цуглаанд оролцсон бага Кю Чан төрөлхийн саажилтын улмаас үүдсэн сөлөр хараатай байсан ч төгс эдгэрсэн гайхалтай явдал боллоо. Бага байхын л хажуу тийшээ хялайх мэт хардаг

хүүгийн минь нүдийг эмч үзээд харааны төв нь хазгай байрлалтай, мэс засал хийхэд маш аюултай бөгөөд хэвийн болох баталгаа байхгүй гэсэн ч тэргүүн пасторын залбирлаар төгс эдгэрсэн юм.

Энэ мэт хоёр хүү минь И Жей руг тэргүүн пасторын залбирлаар эдгэрч, эрүүл саруул өсч бойжиж, надад санаа тавьдаг эхнэр минь гэр бүлийн ерөөл авахад би тухайн үедээ баярлаж, талархдаг ч тэр ивээл хайрыг том зүйлд тооцдоггүй байлаа.

Тэгээд 2017 оны бусдад туслах гэсэн ажил минь санаандгүйгээр хүнд байдалд орж, миний төлөө залбирч байсан эхнэр минь тэр асуудал бага зэрэг цэгцэрч эхэлтэл ажил дээр эргэлт хийлгэж, мөргөл хийх ёстой гэлээ. Би өөрийн хүчээр асуудлыг шийдэж чадахгүй тул яалтгүй Бурханыг түшиглэхээс өөр зам байсангүй.

2018 оны 2-р сар 24 нд айл эргэлтийн мөргөл хийлгэж, их ивээл авч Бурхан яг л миний сэтгэлийг мэдэж, тайтгаруулж байгаа мэт байлаа. Тэгээд 3-р сарын 4н өдөр Эзэний өдөр их мөргөлд оролцохоор сүмдээ ирсэн юм. Мөргөлийн цагт би тасралтгүй уйлж, нулимс минь бөмбөрсөөр байв.

23н жилийн дараа удаан хугацаанд сүмдээ ирээгүй намайг маргалгүй, миний бүх байдлыг мэдэж байгаа гэсэн мэдрэмж төрж, үүнээс хойш хоньчны үг сургаалиар өөрчлөгдөж эхлэв.

‘Загалмай үг’, ‘Итгэлийн хэмжээ’, ‘Тэнгэрийн орон’ зэрэг тэргүүн пасторын сургаалийг сонсч, номийг унших тусам энэ гүн гүнзгий үг сургаальд гайхан биширч байв. Сүмдээ явахад сэтгэлийн ачаанууд нэг нэгээрээ унаж хөнгөрч байгаа нь мэдрэгдэж, итгэгч нартаа сэтгэлдээ бүгдийг агуулж буй тэргүүн пастор, өчүүхэн ч маргах юмгүй эвтэй итгэгч нарын төрх зэрэг ивээл дүүрэн байна.

Би архи уухаа больж, Эзэний өдрөө сахьж, боломж гарвал баасан гаригийн шөнийн мөргөл, Лхагва гаригийн мөргөлд оролцож бага зэрэг залбирдаг болсон. Үнэхээр маш их ивээл бас боломж өгсөөр байтал урьдын л адил ертөнцтэй нийцэн амьдарч байсан намайг маш удаан тэвчин хүлээж өгсөн Бурхан Аавдаа, мөн Эзэний хайранд талархал өргөө.

Түүнчлэн эрх мэдэлт хүчээр тэр хайрыг илчлэн харуулж, сүнснийг минь түшиж өгсөн хайрт тэргүүн пастордаа чин сэтгэлээсээ талархал өргөө.

“70 жилийн турш огт сонсдоггүй байсан зүүн чих нээгдэж, хараа сайжирав”

Гуан Уг хуа сүмд үйлчлэгч (79 нас, 1-р Их бүлэг 4-р бүлэг)

Би найм нас хүрдэг жилээ халуун өвчин тусч түүний дараа зүүн чих минь огт сонсохоо больж, найзуудтайгаа нийлж чадалгүй ганцаараа их уйлдаг байв. Тэгээд дүү нараа харж сургуульдаа ч олигтой явж чадалгүй 19 тэйдөө хадамд гарсан юм.

Чих маань сайн сонсохгүй дээрээс би Андуных тул Тэгү аялагыг сайн ойлгохгүй байлаа. Сайн ойлголцохгүй болохоор маанаг гэж дуудуулан амьдарч байтал Бурхан миний шаналсан уйтгартай сэтгэлийг эрхэмд тооцон хүлээн авсан юм.

2016 оны 5-р сарын 1 Эзэний өдөр, намайг номлосон хүнтэй хамт Манмин сүмд ирээд, сүмээр хаалгаар орох тэр агшин яг л цэцгийн талбайд ирсэн мэт санагдаж байв.

Маш цэвэр цэмцгэр сүмд итгэгч нарийн царай ч баяр хөөрөөр бялхаж байлаа. Эзэний өдрийн мөргөл эхэлж, сургаал айлдахаар индэрт гарч ирсэн И Жей руг тэргүүн пасторыг харахад даруу төлөв боловч, сүнслэг гэрэл хүчтэйгээр мэдрэгдэж байв.

“Тэм нүгэл хийлгүй, худал хэлэлгүй, Бурханд чин сэтгэлээсээ итгэвэл Тэнгэрийн орон руу явна” гэж айлдаж буй тэргүүний пасторын сургаал үнэхээр ивээл дүүрэн байлаа. Сургаал дотор амьдрах гэж зүтгэх тусам урьд нь мэдэрч үзээгүй амар тайван, амралтыг эдлэж эхэлсэн юм. GCNтелевизээр дамжуулан Даниел залбиралд оролцон, өчүүхэн намайг үзэсгэлэнтэй сайхан чуулган руу удирдаж өгсөн Бурхандаа талархан залбирал өргөсөн юм.

Тэгээд 2018 оны эхээр хүмүүсийн төлөө бүх хүчээ шавхан, тэнхээ алдаж, нүд нь

ч сайн харж чадахгүй, чих ч сайн сонсч чадахаа больсон хоньчны дүр дөрхийг харахад сэтгэл маш их өвдөж байлаа. Үүнээс хойш тэргүүн пасторын нүдийг сайн хардаг, сонсгол сайжируулж өгөөч үргэлж залбирдаг болсон юм.

Хамгийн гайхалтай нь 3-р сарын үед тэргүүн пасторын дуу хоолой аяархан дуу чихэнд сонсдож эхлэсэн юм. Өмнө нь сайн сонсч чадахгүй болохоор баруун чихээрээ бүхнийг сонсох гэж хичээдэг байсан бол энэ удаад арай өөр байлаа. Үүний дараахан ярилцахад, мөргөлд оролцоход ч үнэхээр сайн сонсдог болсон юм. Насан туршдаа зүүн чих огт сонсдоггүй уйтгарт амьдралаар амьдарч ирсэн намайг энэрч өгч, чихний эдгэрлийн гуйгаагүй байхад ч зүрх сэтгэлийн хүсэлд ч хүртэл Бурхан минь хариулж өгсөн юм. Халлелуяа!

Зөвхөн энэ ч биш өмнө нь хараа муутай учир нүдний шилэндээ нэмэлт цлиндэр шил хийгээд ч жижиг үсэг сайн харагдахгүй байсан бол одоо нэмэлт шил байхгүй ч жижиг шил сайн харагддаг болсон.

Эзэн дотор жинхэнэ аз жаргалыг мэдрүүлж, одоо наяд хүрч буй насандаа харинч нүдний хараа сайжирч, огт сонсдоггүй чих сонсдог болгож өгсөн хайрын Бурхандаа бүх талархал алдрыг өргөө.



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminnews@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин